

Тодруулгын асуултууд

1. Тус тендерийн материалд суурилуулах тоолуур ба бараа материалын жагсаалт тусгагдаагүй байна. Иймд нийт хэдэн төрлийн тоолуураас хэд хэдэн ширхэгийг суурилуулахыг тодорхой болгож өгнө үү?
2. Тус тендерийн материалаас үзэхэд Өмнөговь аймгийн хэд хэдэн сумдаар тоолууруудыг суурилуулахаар заагдсан байна. Иймд эдгээр суурилуулах цэгүүдийн байршил ба тухайн цэгт хэдэн тоолуур суурилагдахыг тодруулж өгнө үү?
3. Тендерийн техникийн тодорхойлолтын *"Ажлын технологийн үндсэн шаардлага"* хэсэгт заасан тоолуур хайрцагт багтахгүй тохиолдолд нэмэлт хайрцаг байрлуулж, монтаж холболт хийх ажил, шаардлагатай материалыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна гэж заасан байна. Эндээс бидэнд ямар байршлууд дээр тоолууруудыг тусад нь хайрцагт нэмэлтээр хийх вэ? Тоо хэмжээг тодорхой болгож өгнө үү.
4. Тендерийн ТООЗ 5.2-т заасны дагуу 0.4-с 35кВ цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт хийхэд тухайн байршил дээрх таслалтыг ӨБЦТС ТӨХК хариуцаж, таслалт залгалтаар хангах бригадыг гаргаж өгөх эсэх, таслалтын төлбөр нь тендерийн төсөвт багтсан эсэхийг тодруулж өгнө үү.
5. Тендерийн техникийн шаардлагын хавсралт 1-т заасан гүйдлийн трансформаторын гүүвэрт тоо хэмжээ заагдаагүй байна. Иймд тус хавсралтын дагуу гүйдлийн трансформаторын тоо хэмжээг гаргаж өгнө үү.
6. Тендерийн техникийн шаардлагад заасан гүйдлийн трансформатор шинэчлэх ажилд РП, ТП-ны үндсэн шинэ/кабелийг задалж, гүйдлийн трансформаторыг солих ажлыг аль тал нь хариуцах вэ?
7. Тендерийн нөхцөлд заагдаагүй борлуулалтын болон гуравлагч програмтай холбох шаардлага гарвал тус зардлыг ӨБЦТС ТӨХК хариуцах эсэхийг тодруулж өгнө үү.
8. Тендерийн нөхцөлд заагдаахгүй Data сим болон дараах ДАТА зардлыг ӨБЦТС ТӨХК хариуцах эсэхийг тодруулж өгнө үү.
9. Тендерийн ТООЗ 5.3-т заасан *"Туршилт хэмжиглэлтийн багаж хэрхсэн"* гэдгийг тодорхой болгож өгнө үү.
10. Тендерийн 3-н фазын 100А-н тоолуурын үндсэн шаардлагад заасан *"Шилжилтийн үеийн хамгийн их чадал"* гэдгийг тодруулж өгнө үү.
11. Тендерийн техникийн тодорхойлолтын *"Ажлын технологийн үндсэн шаардлага"* хэсэгт заасан суурилуулалт хийхээс өмнө сургалт зохион байгуулах гэсэн шаардлагад ямар сургалтыг заавал хийсэн байхыг хэлж байна вэ? Суурилуулалт, тохиргооны талаарх сургалт уу эсвэл ухаалаг тоолуурын систем дээр ажиллах сургалт уу?